



**ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ
АЖЛЫН АЛБА**

**ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН
/ХУРААНГУЙ/**

**Улаанбаатар хот
2024 он**

ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Улсын Их Хурлын 2024 оны сонгуулийн үр дүнд эмхлэн байгуулагдсан хамтарсан “Засгийн газрын 100 хоног”-ийн үйл ажиллагааны хүрээнд Хяналт, үнэлгээний Үндэсний хорооноос хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг толилуулж байна.

Нэг. Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны анхдугаар хуралдаан

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 5-д Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, төрийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах асуудлыг эрхлэхээр заасантай холбогдуулан Засгийн газрын 2024 оны 07 дугаар тогтоолоор Хяналт, үнэлгээний Үндэсний хороог байгуулж, тус хорооны бүрэлдэхүүн, дүрмийг баталсан.



Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5^{1.1} дэх хэсэгт “Хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий төрийн захиргааны төв байгууллага эрсдэлийн үнэлгээг харгалзан дараа жилд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөг Хяналт, үнэлгээний үндэсний хороонд ирүүлнэ” гэж, 5^{1.2} дахь хэсэгт “Хяналт, үнэлгээний үндэсний хороо энэ хуулийн 5^{1.1}-д заасан төлөвлөгөөг өмнөх жилийн 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор батална” гэж заасан тул Үндэсний хорооны анхдугаар хуралдааныг 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр товлон зарлаж, үндсэн 5 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

САЛБАРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь-тувшин	Зорилгот түвшин	Хугацаа	Хяналт шалгалтын байгууллага
1	2	3	4	5	6	7	8
ТӨЛӨВЛӨГӨӨТ ХЯНАЛТ ШАЛГАЛТ							
1	Нэр бүхий аймаг/уулд геолог уул уурхайн салбарын их, дунд зэвсэглэлт үйлдвэрийн 106 объектод төлөвлөгөөт шалгалт хийх (Өмнөговь, Дундговь, Дорноговь, Улаанбаатар)	Улсын төсөв	Шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь	81.6%	100%	III улирал	АУЗБЯ аймаг нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэж
2	Шөвгийн болон шаардлагын хяналтын чиглэлээр их, дунд зэвсэглэлт үйлдвэрийн 85 ам агуулам нэгжид төлөвлөгөөт шалгалт хийх (Завхан, Архангай, Говь-Алтай, Баянхонгор, нийслэл)	Улсын төсөв	Шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь	75%	80%	III улирал	АУЗБЯ аймаг нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэж
3	Төв суурин газарт газрын тосны бүтээгдэхүүн худалдаа, түгээх үйл ажиллагаа эрхэлж буй их, дунд зэвсэглэлт үйлдвэрийн 273 объектод төлөвлөгөөт шалгалт хийх	Улсын төсөв	Шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь	75%	80%	III улирал	БОУАБЯ ГЕОХОР аймаг нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэж
4	Байгаль орчны хяналтын чиглэлээр их, дунд зэвсэглэлт үйлдвэрийн 973 объектод төлөвлөгөөт шалгалт хийх	Улсын төсөв	Шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь	81%	84%	III улирал	БОУАБЯ аймаг нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэж

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 57.2 дахь хэсэг, Засгийн газрын 2024 оны 07 дугаар тогтоолын 2 дугаар хэсгээр батлагдсан "Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга"-ийн 2.7 д-аасны тус тус үндэсэн ТОГТООХ нь.

- Салбарын хяналт шалгалтын 2025 оны төлөвлөгөөг хэвсгалтаар баталсуй
- Энэхүү төлөвлөгөөнд ийнхүүлэн тухайн салбарын хяналт шалгалтад хямагдах объектын жагсаалтыг холбоодыг хууль тогтоомжийг заавны дагуу батлан, хэрэгжүүлж салбарын хяналтын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүд, холбоодыг өгөөлгөлийн дарга нарт даалгасуй
- Хяналт шалгалтын уялдааг хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж амжилтыг Алсын албаны дарга Н.Лозавадорь-а үргэлж болгосуй.

МОНГОЛ УЛСЫН САЙД
ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ
ҮЙДСЭНИЙ ХОРООНЫ ДАРГА

1. Үндэсний хорооны хуралдааны дэгийг батлах;
2. Салбарын хяналт шалгалтын 2025 оны нэгдсэн төлөвлөгөөний төсөл;
3. Үндэсний хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө;
4. Хяналт, үнэлгээний тогтолцоог олон улсын жишигт хүргэх, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болон дунд, богино хугацааны бусад бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг уялдуулан үнэлэх чиглэлээр олон улсын үнэлгээний цогц систем (DME)-ийг нэвтрүүлэх ажлын явцын талаар;
5. Бусад асуудал.



Хоёр. Төрийн захиргааны төв байгууллагын хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлдэг газар, хэлтсийн удирдах албан тушаалтнуудтай хийх зөвлөлдөх уулзалт

Засгийн газрын бодлого, үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх, батлагдан гарсан ууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг үр

дүнтэй зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдал, шийдвэр гаргах үйл явц, хэрэгжилтэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх тал дээр анхаарч ажиллаж байна.



Төрийн захиргааны төв байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын болон хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлдэг газар, нэгжийн удирдах албан тушаалтнуудтай зөвлөлдөх уулзалт хийж, салбарын хууль, эрх зүйн орчныг сайжруулах, захиргааны хяналт, удирдлагын хүрээн дэх хяналт шалгалтыг зохион байгуулах, салбарын хэмжээнд тулгамдаж байгаа зарим асуудлын талаар санал солилцож, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны бодлого, үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөв.

Гурав. Орон нутгийн томилолт

3.1. Сургалт, хэлэлцүүлэг

Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны Ажлын алба, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газартай хамтран Архангай, Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон, Булган, Хөвсгөл, Говьсүмбэр, Увс, Төв, Хэнтий, Сүхбаатар аймагт хяналт, үнэлгээний талаар баримтлах бодлого, төрийн байгууллагын үйл ажиллагааны үнэлгээ, мониторинг хийхэд анхаарах асуудал, төрийн хяналт шалгалтын үйл ажиллагаа, цаашид хийж хэрэгжүүлэх ажлын талаар орон нутаг дахь төрийн албан хаагчдад мэдээлэл өгөх, процессын дахин инженерчлэл, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал болон үнэлгээ мониторинг хийх үе шатыг олон улсын арга, аргачлалын дагуу боловсруулах, олон улсын үнэлгээний



цогц систем (DME) нэвтрүүлэх сэдвээр сургалт, хэлэлцүүлгийг 2024 оны 11 дүгээр сарын 04-21-ний өдрүүдэд амжилттай зохион байгуулсан.

Аймаг, орон нутгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга нар төрийн байгууллага дахь үйл ажиллагаанд хяналт хэрхэн хэрэгжиж байгаа, цаашид салбарын хяналтыг бодлогын түвшинд анхаарч үзэх талаар, тухайлбал, төрийн үйлчилгээг иргэдэд чанар, хүртээмжтэй хүргэхийн тулд төрийн алба хаагчид, салбарын хяналтын алба хаагчдын ажиллах орчин, нөхцөл, боломжийг бүрдүүлэх нь нэн чухал шаардлагатай байгаа тухай, түүнчлэн төрийн байгууллагуудад хяналт, шалгалт хийгдэх үнэлгээний арга, аргачлалыг шинэчлэх цаг үетэйгээ нийцүүлэх шаардлага тулгамдаж буй талаар саналаа илэрхийлсэн.



Сургалт, хэлэлцүүлгийн зорилго аймаг, нийслэлийн Засаг дарга, улсын төсөвт үйлдвэрийн газар, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хууль ёсыг сахиулах, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах замаар төрийн байгууллагын хариуцлагыг сайжруулах, шударга ёсыг сахиулах, төрийн үйлчилгээний хүртээмжтэй, ил тод байдлыг нэмэгдүүлэх, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал болон үнэлгээ мониторинг хийх үе шатыг олон улсын арга, аргачлалын дагуу боловсруулахад чиглэгдэж байв.

Мөн үнэлгээ, мониторингийн эрх зүйн орчин, тогтолцоо, шинэчлэлийн бодлогын талаар “Мониторинг хийх нийтлэг журам”, “Үнэлгээ хийх нийтлэг журам”, “Төрийн байгууллагын гүйцэтгэлийн удирдлагыг дүгнэх журам” зэрэг гурван журмын төслийн танилцуулгыг хийж, журмын төсөлтэй холбогдуулан иргэд, албан тушаалтнуудаас өгсөн саналыг авч нэгтгэсэн.

3.2. Ерөнхий сайдын албан даалгаврын хүрээнд салбарын хяналтын улсын байцаагч нартай хийсэн уулзалт

“Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан 2024 онд багтаан хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг

хангах ажлын хүрээнд Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Н.Лхагвадорж тэргүүтэй албан тушаалтнууд Баянхонгор, Говь-Алтай, Ховд аймгийн салбарын хяналтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг улсын байцаагч нартай уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулав.

Уулзалтаар Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 01 дүгээр албан даалгаврын хүрээнд хяналт шалгалтын давхардлыг бууруулах, мөн Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны хуралдаанаас гарсан тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааны талаар санал солилцож, сонирхсон асуултад хариулт өгсөн.

Уулзалтад аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга, мөн Засаг даргын Тамгын газрын холбогдох албан тушаалтнууд, улсын байцаагч нар оролцож, салбарын хэмжээнд тулгамдаж байгаа зарим асуудлын талаар санал, хүсэлтээ илэрхийлсэн.



Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны үндсэн чиг үүрэг Монгол Улсын төрийн захиргааны төв байгууллагууд болох яамд, аймаг, нийслэлийн Засаг дарга, тэдгээрийн Ажлын албад, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хяналт, шалгалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хяналт шалгалт хийж байгаа байгууллагуудын үйл ажиллагааны уялдааг хангах үүрэгтэй бөгөөд Засгийн газрын дэвшүүлсэн зорилтын хүрээнд төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, мөн салбарын хяналт шалгалт давхардаж байгаагаас шалтгаалж аж ахуйн

нэгжүүдэд хүндрэл, чирэгдэл учирч буй талаар Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний 2 байгууллага хамтран судалгаа хийхэд үндэсний хэмжээнд хяналт шалгалтад хамрагдаж буй 15 байгууллага тутмын нэгийг хамруулахыг зорин, хяналт шалгалтын ажлын уялдаа холбоог хангаж 14.8 хувь буюу давхардлын асуудал дээр аж ахуйн нэг байгууллага, бизнес эрхлэгчдийн нуруун дээр ирж буй хүндрэл, чирэгдэлийг бууруулах зорилт тавин ажиллаж байна.

Дөрөв. Олон улсын байгууллагын сургалт, уулзалт

4.1. Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын дунд хэрэгжүүлсэн “Орон нутагт үр дүнд суурилсан нэгдсэн удирдлагыг хэвшүүлэх” дэмжих хөтөлбөрийн үр дүнгийн танилцуулга

Үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлт, гүйцэтгэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний арга, аргачлалын дагуу төрийн албан хаагчдыг чадавхжуулах, нэгдсэн удирдлагын хэрэгжилтийг идэвхжүүлэх зорилгоор аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын дунд хэрэгжүүлсэн “Орон нутагт үр дүнд суурилсан нэгдсэн удирдлагыг хэвшүүлэх” дэмжих хөтөлбөрийн үр дүнг танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан. Европын Холбооны санхүүжилттэй “Монгол Улсад тогтвортой хөгжлийн зорилттой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нь” төслийн хүрээнд хэрэгжиж байгаа энэхүү хөтөлбөрийн үр дүнд тэргүүн байр эзэлсэн аймгийн Засаг даргын Тамгын газрын баг, хамт олонд Европын Холбооноос Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд бөгөөд Төлөөлөгчийн газрын тэргүүн, хатагтай Ина Марчиулионите /Ina Marciulionite/-гийн хамт шагнал гардуулав.

1-р байранд Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газрын баг, хамт олон: “Сүхбаатар аймгийн 2025 оны төсвийн төслийг үр дүнд суурилсан аргачлалаар боловсруулсан нь”;

2-р байранд Булган аймгийн Засаг даргын Тамгын газрын баг, хамт олон: “Булган аймгийн 2024 оны эхний хагас жилийн үр дүнд суурилсан төсвийн гүйцэтгэлийн тайлангийн танилцуулга”;

3-р байранд Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрын баг, хамт олон: “Говьсүмбэр аймгийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төслийг үр дүнд суурилсан аргачлалаар боловсруулсан нь” тус тус шалгарав.



4.2. НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжүүлж байгаа төслийн багийхантай хийсэн уулзалт

Европын Холбооны санхүүжилтээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжүүлж байгаа “Монгол Улсад тогтвортой хөгжлийн зорилттой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нь” төслийн багийн менежер Б.Нинжин, төслийн ахлах зөвлөх С.Сүхдэлгэр, төслийн зөвлөх Д.Намхайдагва, Г.Цэрэнжаргал нарыг хүлээн авч уулзав.



Төслийн хүрээнд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газартай хамтран “Өглөөний уулзалт”-ыг төрийн захиргааны төв байгууллагын болон харьяа агентлагийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан нэгжийн албан хаагчдад 14 хоног тутам дараах сэдвээр сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулаад байна. Үүнд:

1. “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн арга зүйн шинэчлэл”;
2. “Мониторингийн арга зүй”;
3. “Бодлогын өртөг тооцох”;
4. “Хяналтын болон хариуцлагын хүрээний талаарх ойлголт ба мониторинг, үнэлгээний мөрөөр хариуцлага тооцох асуудал, шийдэл”;

5. “Уламжлалт ба үр дүнд суурилсан төлөвлөлтийн арга зүйн хүрээнд ялгаатай боловсруулагдсан баримт бичигт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх асуудал, шийдэл”;
6. “Хөтөлбөр, үр дүнгийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээний ач холбогдол, уялдаа”;
7. Төрийн албан хаагчдын чадавхыг тасралтгүй бэхжүүлж, харилцан туршлага солилцох боломжоор хангах, тулгамдсан асуудлаар санал солилцох, үр дүнд суурилсан явцын болон эцсийн үнэлгээ хийх арга зүйд суралцах, бодлогын зорилт, байгууллагын үйл ажиллагаа, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хянах, шинэ арга аргачлалуудыг холбогдох салбар, үйл ажиллагаанд тусган ажиллах талаар мэдээлэл авч, цаашид тогтвортой хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой болохыг талууд ярилцсан байна.

4.3. “Хөтөлбөр, үр дүнгийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээний ач холбогдол, уялдаа” сургалт, хэлэлцүүлэг

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны Ажлын албатай хамтран төрийн захиргааны төв байгууллагын хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлдэг албан тушаалтнуудад “Хөтөлбөр, үр дүнгийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээний ач холбогдол, уялдаа” сэдвээр сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулав.



4.5. НҮБ-ын Европын эдийн засгийн комиссын зөвлөлтэй хийсэн уулзалт

Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Н.Лхагвадорж Нэгдсэн Үндэстний Байгууллагын Европын эдийн засгийн Комиссын зөвлөх, ноён Крис Дайкенсийг хүлээн авч уулзлаа. Уулзалтын үеэр талууд байгаль орчны гүйцэтгэлийн үнэлгээний 2 дугаар тайлан болон салбарын хяналт шалгалтын тулгамдсан асуудлын талаар санал солилцож, сонирхсон асуултад хариулт өгөв.




Тав. Салбарын хяналтын чиглэлээр хийсэн уулзалт, хэлэлцүүлэг

5.1. Салбарын хяналтын газрын удирдлагуудтай хийсэн уулзалт


Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны хуралдаанаар салбарын хяналт шалгалтын 2025 оны нэгдсэн төлөвлөгөөг баталсантай холбогдуулан зарим агентлагийн дарга нар болон яамны Салбарын хяналтын газрын удирдах албан тушаалтнуудтай уулзалт зохион байгуулж, Үндэсний хорооны тогтоол, шийдвэрийг танилцуулав.

Мөн тус уулзалтаар Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 01 тоот албан даалгаврын хүрээнд хяналт шалгалтын давхардлыг бууруулах болон салбарын хэмжээнд тулгамдаад байгаа зарим асуудлын талаар харилцан санал солилцож, Үндэсний хорооны бодлого, үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөв.



Зургаа. Иргэд, олон нийттэй харилцах “11-11 төв”-д ирүүлсэн өргөдөл, гомдлын тайлан мэдээ

Иргэд, олон нийттэй харилцах “11-11 төв”-д ирүүлсэн өргөдөл, гомдлын дийлэнх хувийг төрийн байгууллага, төрийн албан хаагчийн хүнд суртал, орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээ, зам, замын засвар үйлчилгээтэй холбоотой асуудал эзэлж байна.



Үүнтэй холбогдуулан өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах өргөдөл, гомдолд түн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосон.

Долоо. Хууль, эрх зүйн орчны шинэчлэл

Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан хамтарсан Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд Хяналт, үнэлгээний Үндэсний хороог шинээр байгуулсантай холбогдуулан Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хяналт шалгалт хийх нийтлэг журам”-д өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5^{1.1} дэх хэсэгт “Хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий төрийн захиргааны төв байгууллага эрсдэлийн үнэлгээг харгалзан дараа жилд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөг Хяналт, үнэлгээний Үндэсний хороонд ирүүлнэ” гэж, 5^{1.2} дахь хэсэгт “Хяналт, үнэлгээний Үндэсний хороо энэ хуулийн 5^{1.1}-д заасан төлөвлөгөөг өмнөх жилийн 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор батална” гэж, мөн Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 07 дугаар тогтоолоор Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны бүрэлдэхүүн, дүрэм, сайдын Ажлын албаны орон тооны хязгаарыг батлахдаа Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 479 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хяналт шалгалт хийх нийтлэг журам”-ын 3.7, 3.8 дахь заалт, 3.13.2 дахь дэд заалтын Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хамаарах чиг үүргийг Хяналт, үнэлгээний Үндэсний хороонд шилжүүлэхээр тусгасан.

Гэтэл “Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны бүрэлдэхүүн, дүрэм, сайдын Ажлын албаны орон тооны хязгаарыг батлах, тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2024 оны 07 дугаар тогтоолыг батлахдаа “Хяналт шалгалт хийх нийтлэг журам”-д өөрчлөлт оруулах дагалдах тогтоолын төслийг боловсруулж, батлуулаагүйн улмаас эрх зүйн акт хоорондоо зөрчилдөхөд хүргэсэн.

Үүнтэй холбогдуулан "Хяналт шалгалт хийх нийтлэг журам батлах тухай" Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 479 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хяналт шалгалт хийх нийтлэг журам”-ын холбогдох заалт, дэд заалтыг Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон “Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны бүрэлдэхүүн, дүрэм, сайдын Ажлын албаны орон тооны хязгаарыг батлах, тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 07 дугаар тогтоолын 4-т заасанд нийцүүлж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт харьяалах зарим чиг үүргийг Хяналт, үнэлгээний Үндэсний хороонд шилжүүлэх зорилгоор “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаад байна.

АЖЛЫН АЛБА